

**СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН “ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН
АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ” ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД
2023 ОНД ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ**

2023 оны 12 дугаар сарын 25

д/д	Хөтөлбөрт тусгагдсан ажил	Хугацаа	Хамрагдах албан хаагчийн тоо	Төсөв	Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
5.1 Орон сууцны талаар:						
1	6.1.1 Орон сууцны зээлтэй албан хаагчийн жилийн орлого, ажлын амжилтыг харгалзан зээлийн үлдэгдлийн 50% хүртэл мөнгөн тусламжийг нэг удаа үзүүлэх.	2, 4 дүгээр улиралд	8-10 албан хаагч	80,000,000	Засаг даргын Тамгын газар болон хороодын ажлын албаны 19 албан хаагчид ар гэрийн нөхцөл, өрхийн орлого, ажлын амжилтыг нь харгалзан орон сууцны зээлийн үлдэгдлээ төлөхөд нь дэмжлэг үзүүлж 167,7 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон.	100
2	6.1.2 Орон сууц, нөхцлөө сайжруулахад нь дэмжлэг үзүүлэх.	2, 4 дүгээр улиралд	15-20 албан хаагч	120,000,000	Засаг даргын Тамгын газар болон хороодын ажлын албаны 9 албан хаагчид ар гэрийн нөхцөл, өрхийн орлого, ажлын амжилтыг нь харгалзан орон сууцны нөхцөлөө сайжруулахад нь дэмжлэг үзүүлж 72,0 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон.	100
3	6.1.3 Орон сууцны урт хугацааны зээлийн урьдчилгаа төлбөрийн тодорхой хэсгийг санхүүжүүлэх.	2, 4 дүгээр улиралд	8-10 албан хаагч	80,000,000	Засаг даргын Тамгын газар болон хороодын ажлын албаны 15 албан хаагчид ар гэрийн нөхцөл, өрхийн орлого, ажлын амжилтыг нь харгалзан өөрийн орон сууцтай болоход нь урьдчилгаа төлбөрийн тодорхой хэсэгт дэмжлэг үзүүлж 116,0 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон.	100
5.2 Эрүүл мэндийн талаар:						
4	6.2.1 Жил бүр албан хаагчдыг дотоодын нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, оношлогоонд хамруулах.	3 дугаар улиралд	Бүх албан хаагчид	18,000,000	Засаг даргын Тамгын газрын ажилтан албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор 2023.10.06-09-ний өдрүүдэд чихрийн шижин өвчлөлөөс	100

					урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх үйл ажиллагаа зохион байгуулж, Чихрийн шижингийн эрт илрүүлэг үзлэг, оношилгоонд 74 хүн хамруулж, өндөр эрсдэлтэй 4 иргэнийг нарийн мэргэжлийн эмчид үзүүлэх, биохимийн шинжилгээ өгөхийг зөвлөсөн. Мөн Монфа ЭМХБ нь дархлаа дэмжих эрүүл мэндийн бүтээгдэхүүнүүд сурталчлан, холестериний хэмжээг үзэн, зөв хооллолт, дасгал хөдөлгөөн хийх, бухимдлаа зөв тайлах аргад суралцах талаар зөвлөгөө мэдээлэл өгсөн. 2023.11.16-нд томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сайн дурын дархлаажуулалтад 54, 2023.12.14-нд цусан дах эрдэс бодисын (цусанд кали, натри, кальци, фосфор, магни, хлор үзэх) болон D витамин дутагдлыг илрүүлэх шинжилгээнд 78 албан хаагчийг тус тус хамруулсан.	
5	6.2.2 Өндөр өртөгтэй эмчилгээ хийлгэж байгаа тохиолдолд өрхийн орлого, нөхцөл байдлыг харгалзан эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлэх	Жилдээ	3-5 албан хаагч	30,000,000	Засаг даргын Тамгын газар болон хороодын ажлын албаны 11 албан хаагчид дотоод болон гадаад улсад эмчилгээ хийлгэхэд нь эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлж 106,0 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон.	100
6	6.2.3. Эрүүл мэндийн үндэс болсон идэвхтэй хөдөлгөөн, биеийн тамирын уралдаан тэмцээн, бэлтгэл сургуулилтыг олон хэлбэрээр өргөн хүрээнд зохион байгуулах.	2,3 дугаар улиралд	Бүх албан хаагчид	10,000,000	Албан хаагчдыг хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих зорилгоор 2023.03.04-ний өдөр “Эрүүл агаар” спорт өдөрлөг зохион байгуулж Богд ууланд алхалт хийсэн. 2023.03.31-04-02-ны өдрүүдэд 5 төрлөөр спортын тэмцээн зохион байгуулж бүх албан хаагчдыг идэвхтэй хамруулсан. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон 9 дүүргийн төрийн албан хаагчдын спортын тэмцээн, дүүргийн Засаг даргын нэрэмжит	100

					спортын тэмцээнд баг тамирчдын бэлтгэн оролцуулсан.	
6.3 Ажиллах нөхцлийг сайжруулах талаар:						
7	6.3.1 Ажлын байрны тавилга эд хогшлийг сайжруулж, ая тухтай нөхцөлийг бүрдүүлэх.	4 дүгээр улиралд		-	Дүүргийн 12-20 дугаар хорооны ажлын албаны байрны өрөөний дотор засал, дээвэр засварын ажил, галч нарын өрөөг тохижуулж, засварлах ажлуудыг хийж, албан хаагчдыг ая тухтай ажиллах нөхцөлийг бүрдүүлж ажилласан. Засварын ажилд нийт 153,0 сая төгрөг зарцуулсан.	100
8	6.3.2 Цаг үеийн шаардлагад нийцсэн техник, тоног төхөөрөмжөөр хангах.	4 дүгээр улиралд		-	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу техник, тоног төхөөрөмжөөр хангах ажлыг зогсоосон.	0
6.4 Албан хаагчдын цалин хөлс, шагнал урамшууллын талаар:						
9	6.4.1 Албан хаагчдад зэрэг дэв олгох, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг журмын дагуу шийдвэрлэх.	Жилдээ	Бүх албан хаагчид	-	2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайлангийн үнэлгээгээр Бүрэн хангалттай, Хангалттай үнэлэгдсэн, зэрэг дэв олгох шаардлага хангасан 34 төрийн захиргааны албан хаагчдад зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох саналыг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлж, 34 албан хаагчид зэрэг дэв, түүний нэмэгдлийг олгосон. Төрийн үйлчилгээний албан хаагчдад ажлын үр дүн, ур чадварыг харгалзан сар бүр үндсэн цалингийн 25 хувь хүртэл ур чадварын нэмэгдлийг олгосон.	100
10	6.4.3 Албан хаагчийн ажлын бүтээмж, амжилт, идэвх зүтгэлийг үндэслэн төрийн одон медаль болон бусад шагналд тодорхойлох.	Жилдээ	5-10 албан хаагч	-	Засаг даргын Тамгын газар, хороодын ажилтан, албан хаагчдаас 2023 онд Алтан гадас одонгоор 2, нийслэлийн Тэргүүний ажилтан цол тэмдгээр 2, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Жуух бичгээр 1, Нийгмийн хамгааллын салбарын тэргүүний ажилтан цол тэмдгээр 3, Санхүү, банкны тэргүүний ажилтан цол тэмдгээр 3, Үндэсний статистикийн хорооны Бүртгэл, статистикийн тэргүүний ажилтан цол тэмдгээр 1, Хүндэт жуух бичгээр 3	100

					албан хаагч тус тус шагнагдсан. 2023 оны жилийн эцсийн ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлсэн үнэлгээний мөрөөр 17 албан хаагчийг төрийн одон медалиар шагнуулахаар тодорхойлж, холбогдох байгууллагад шагналын материалыг хүргүүлсэн.	
Дундаж хувь				100 хувь		

ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

В.ГОМБОДОРЖ

НЭГТГЭСЭН:
ХҮНИЙ НӨӨЦ, ЁС ЗҮЙ, ХӨРӨНГӨ ОРЛОГЫН
МЭДҮҮЛЭГ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

М.ОЧМАА